

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08-р сарын 26-ны өдөр

№ А/22-Т

Улаанбаатар хот

Охин компанийн хувьцааг худалдах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 8.4 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.19 дах заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1 дэх заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагын дагуу Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны чиглэлээс өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг охин компанийн хувьцааг бусдад шилжүүлэхтэй холбоотойгоор Компанийн 90%-ийн хөрөнгө оруулалттай “Инвескор Эй Ай Лаб” ХХК, 99.84%-ийн хөрөнгө оруулалттай “Инвескор Жапан” ХХК-ийн хувьцааг толгой компани “Эс Ай Би Жэй Капитал” ХХК-д энэхүү тогтоолын 2-т заасан үнэлгээгээр шилжүүлэхийг зөвшөөрсүгэй;
2. “Инвескор Эй Ай Лаб” ХХК болон “Инвескор Жапан” ХХК-ийн хувьцааны үнэлгээний нөхцөлийг хэлцэлд оролцох талуудын хамт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын 1-д заасан хувьцааны шилжүүлэг нь “Инвескор Эй Ай Лаб” ХХК болон “Инвескор Жапан” ХХК-ийн бусад хувьцаа эзэмшигчдийн Хувьцаа худалдан авах давуу эрхээсээ татгалзсан нөхцөлд биелэх болохыг дурьдсугай.
4. Энэхүү тогтоолын хүрээнд “Инвескор Эй Ай Лаб” ХХК болон “Инвескор Жапан” ХХК-ийн хувьцааг шилжүүлэхтэй холбоотойгоор Компанийг төлөөлөх бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д олгосугай;
5. “Инвескор Эй Ай Лаб” ХХК-ийн Хувьцаа шилжүүлэх гэрээг байгуулахдаа тус компанаас “Инвескор ББСБ” ХК-д үзүүлж буй үйлчилгээний ашгийн маржины түвшинг хувьцаа шилжих үеэс өсгөхгүй байх нөхцөлийг тусгахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай;
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан), хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (А. Энэрэл)-д даалгасугай.

“ИНВЕСКОР ББСБ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

